

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2023/01/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Говьсүмбэр аймаг
2023 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас: 70543179
Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр
Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Анхтуяа
Цахим хаяг: ankhtuyab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govissumber@audit.gov.mn

2023.09.15 № 46
танай _____-ны № _____-т

АЙМГИЙН "ТОХИЖИЛТ СҮМБЭР"
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ц.ЭНХЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны "Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн орлого, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн "Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

008020185

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	37,942,886.95	33,269,457.03
1.1.2	Дансны авлага	101,171.00	9,254,272.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	27,644.13	-
1.1.4	Бусад авлага	18,117,045.88	26,425,832.22
1.1.6	Бараа материал	90,960,465.00	55,828,800.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	147,149,212.96	124,778,361.25
1.2.1	Үндсэн хөрөнгө	8,832,680,125.23	8,325,203,039.26
1.2.2	Биет бус хөрөнгө	117,399,998.49	109,720,727.71
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	8,950,080,123.72	8,434,923,766.97
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,097,229,336.68	8,559,702,128.22
2.1.1.1	Дансны өглөг	116,279.01	0.00
2.1.1.3	Татварын өр	-	4,198,749.85
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	5,506,793,340.82	4,198,749.85
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	5,506,677,061.81	5,945,584,460.81
2.2.20	Өр төлбөрийн нийт дүн	5,506,793,340.82	5,949,783,210.66
2.3.1	Өмч: - төрийн	2,202,002,208.14	2,202,002,208.14
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	6,805,330.88	6,805,330.88
2.3.9	Хуримтлагдсан ашиг	1,381,628,456.84	401,111,378.54
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,590,435,995.86	2,609,918,917.56
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	9,097,229,336.68	8,559,702,128.22

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	82,479,837.00	99,031,352.00
2	Борлуултын өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	82,479,837.00	99,031,352.00
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	461,153,352.90	651,384,072.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	990,752,672.18	1,682,256,202.30
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	44,550,478.74	48,676,300.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-

16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(491,669,961.02)	(980,517,078.30)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(491,669,961.02)	(980,517,078.30)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараахь ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(491,669,961.02)	(980,517,078.30)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	-	750,415,424.00
25	Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	НИЙТ ДҮН
1	[Ү0] оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,202,002,208.14	6,805,330.88	1,381,628,456.84	3,590,435,995.86
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	2,202,002,208.14	6,805,330.88	-	3,590,435,995.86
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
9	[Ү1] оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,202,002,208.14	6,805,330.88	-	3,590,435,995.86
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	2,202,002,208.14	6,805,330.88	-	3,590,435,995.86
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(980,517,078.30)	(980,517,078.30)

13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
17	[Y2] оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,202,002,208.14	6,805,330.88	401,111,378.54	2,609,918,917.56

/төгрөгөөр/

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	676,951,707.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	38,848,626.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	2,759,717.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	378,308,972.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	-	257,034,392.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	665,741,025.92
1.2.1	Ажиллагчдад төлсөн	-	206,743,176.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	63,100,837.86
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	-	258,114,109.20
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	-	92,514,270.50
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	31,634,160.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-	12,270,318.36
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	-	1,854,647.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	-	8,205,732.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(4,673,429.92)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгө орлогын дүн (+)	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-

2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	-	-
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөр төлсөн	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-	(4,673,429.92)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	37,942,886.95
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	33,269,457.03

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 248.0 сая төгрөгийн 8 алдаа илэрснээс завсрын аудитаар 20.1 сая, аудитын явцад 227.9 сая төгрөгийн алдааг залруулсан байна. Үүнд:

7 сард цалин олгоходоо ажилласан хоногийг буруу тооцоолж 19 хүнд 0.1 сая төгрөгийн хоолны мөнгө илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Сангийн сайдын 347 дугаар тушаалаар батлагдсан хавсралт НХМаягт ЦХ-2 дахь заалтуудыг зөрчсөн, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй

Хангамжийн болон аж ахуйн материалын дансанд картаар ашиглалтад байгаа, одоо ашиглагдаж байгаа бараа материалыг үлдэгдэлтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1, 1.27 дахь стандарт, толилуулга, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй

Мөнгөн гүйлгээний тайланд 20.0 сая төгрөгийн зарлага тус бүрийг үзүүлэлтийн дагуу ангилж бүртгээгүй

Мөнгөн гүйлгээний тайланд 86.2 сая төгрөгийн 4 орлого, 18 зарлагыг ангилал зөрүүтэй бүртгэсэн

Хог хаягдлын хураамжийн 14.2 сая төгрөгийн авлага дутуу бүртгэсэн

"Өнгө нэмэх холбоо" ТББ-тай байгуулсан хог хаягдлын менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу 6.0 сая төгрөгийн урьдчилж шилжүүлсэн зардлаар авлага үүсгээгүй

Ерөнхий журналд 118.2 сая төгрөгийн борлуулалтын орлого, борлуулсан бүтээгдэхүүний өртгийг үнийн дүн зөрүүтэй бүртгэсэн

Цэвэр бохир усны зардалд өр төлбөргүй боловч өөр байгууллагын 3.3 сая төгрөгийн өр төлбөрийг төлсөн нь тус тус Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.6, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй

Аудитаар нийт 0.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 0.3 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 2 зөвлөмж өгсөн.

5.1. Төлбөрийн акт

5.1.1 Ээлжийн амралтын олговрыг цалин хөлстэй давхардуулан 2 албан хаагчид нийт 0.04 сая төгрөгийн цалин, анхан шатны баримтын бүрдэлгүй 2 хүнд илүү цаг, 9 хүнд хоног илүү тооцоолж олгосон нийт 0.3 сая төгрөг олгосон

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалын хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.1, 3 дугаар зүйлийн 3.1, Сангийн сайдын 347 дугаар тушаалаар батлагдсан хавсралт НХМаягт ЦХ-2 дахь заалтууд, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Албан шаардлага өгөөгүй

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын бүртгэл тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Жолоочийн тооцооны хуудсанд тухайн байгууллагын автомашин нь ямар албан тушаалтны ямар хэрэгцээнд үйлчилсэн талаарх гүйцэтгэлийг бичээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийг нөхөх заавар НХМаягт ТМ-4" дахь заалтуудыг зөрчсөн, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жолоочийн тооцооны хуудсанд ямар албан тушаалтны ямар хэрэгцээнд үйлчилсэн талаарх гүйцэтгэлийг тодорхой бичих, хэдэн км зарцуулснаа хянаад гарын үсэг зурах, нягтлан бодогч тооцоог хийж шатахууны хэтрэлт хэмнэлтийг гаргах

2. Цалин, хөлстэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ын дагуу илүү цагийн хөлсийг тооцож олгоогүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.1, 109.2, 109.4, ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1, 2.1.2, 2.1.3, 2.2 дахь заалтуудыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дундаж цалин хөлс тодорхойлох журмын дагуу илүү цагийн хөлсийг тооцож олгох

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ	8	248.0	2	9.3	6	238.7	9	248.0				
Дүн	8	248.0	2	9.3	6	238.7	9	248.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ	5	0.32	2	0.32			3	-				
Дүн	5	0.32	2	0.32			3	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ	2	14.6			1	14.6	1	-
Дүн	2	14.6			1	14.6	1	-
Нийт дүн	2	14.6			1	14.6	1	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	ОНӨААН	1	1			1			
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			